



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, худалдан авах ажиллагааг хуулийн
хүрээнд хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх
шаардлагатай байна.

Аудитын код: ДГА-2020/01-ГА

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг
2020 оны 04 сар

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 70522734 Цахим хаяг:
dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: Ч.Хэрлэнчимэг
Утас: 70523020 Цахим хаяг:

Ахлах аудитор: Ц.Лүндэгмаа
Утас: 70523020 Цахим хаяг
lundegmaa.ts@audit.gov.mn

Аудитор: П.Энхбаяр
Цахим хаяг:
enkhbayar.p@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, Тэргүүлэх аудитор Ч.Ариунаа Аудитын менежер Ч.Хэрлэнчимэг Ахлах аудитор Ц.Лүндэгмаа Аудитор П.Энхбаяр 2020 оны 4 дүгээр сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7052-2734, 7052-3020 дугаарын утас, 7052- 2734 дугаарын факсаар харилцана уу ХАЯГ: Орон нутгийн өмчийн 3-р байр	Товчилсон үгийн тайлбар3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4-5 Бүлэг 1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт хууль, журмын дагуу үндэслэлтэй хийгдээгүй байна. 1.1. Аймгийн хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт хуулийн шаардлагад нийцэхгүй байна.....6-7 1.2. ИТХ-аас хуулийн заалтыг зөрчиж төсөл арга хэмжээний төсөв баталснаас орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, үр дүн хангалтгүй байна.....8-9 Бүлэг 2. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг сайжруулж үр нөлөөг дээшлүүлэх хэрэгтэй байна. 2.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааны үр дүнг сайжруулах шаардлагатай байна.....10-15 2.2. Гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй байна.....16-17 2.3. Хөрөнгө оруулалтын дотоод хяналтыг бий болгож, ажлын бодит гүйцэтгэл, санхүүжилтэд тавих захиалагчийн хяналтыг сайжруулах хэрэгтэй байна.....17-20 Бүлэг 3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ашиглалтыг сайжруулах, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна. 3.1. Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн алдаанаас шалтгаалж хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээг бүрэн ашиглаагүй байна.....21-22 3.2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчил давтагдан гарсаар байна.....22-23 Аудитын дүгнэлт.....24-25 Холбогдох байгууллагын санал.....26-29 Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар.....30 Аудитын зөвлөмж.....31-32
--	--

Товчилсон үгийн тайлбар

ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа болон ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ТББ	Тендерийн баримт бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУ	Монгол улсын
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТХШС	Төрийн хяналт шалгалтын стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ХОХБХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэс
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ХА	Харьцуулалтын арга
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ЗАА	Захирагчийн ажлын алба
НД	Нийгмийн даатгал
ХОХБХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэс
ХО	Хөрөнгө оруулалт
БНЗӨБЦТС	Бага нуур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх салбар
ТӨХ	Төрийн өмчийн хороо
НББ	Нягтлан бодох бүртгэл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, аудитын нэр

Аудитын нэр: “Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”

Аудитын код: ДГА-2020/01-ГА

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: МУЕА-ын 2019 оны А/100 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан аймаг, нийслэлийн гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, Төрийн аудитын тухай хуулийн 15.2-т заасны дагуу ТАБ-ын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, төсөл арга хэмжээний хэрэгжилт нь үр нөлөө, үр ашигтай байгаа эсэхэд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитын дэд зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийсэн. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн эсэх.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх
- Хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцсон эсэх

Хамрах хүрээ: Аудитаар орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Замын-Үүд сумын ЗДТГ-ыг хамруулан шалгав.

Ерөнхий мэдээлэл: Аймгийн ИТХ-ын 2018 оны 09/08 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд шинээр хэрэгжих 6466.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 45 ТАХ, өмнөх оноос дамжин хэрэгжих 4757.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 ТАХ, замын сангийн хөрөнгөөр шинээр хэрэгжих 410.2 сая төгрөгийн 6 ТАХ, өмнөх оноос дамжин хэрэгжих 826.7 сая төгрөгийн 4 ТАХ, нийт 12496.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 66 ТАХ хэрэгжүүлэхээр баталж, аймгийн ИТХ-ын 2019 оны 11/09 дүгээр тогтоолоор 582.5 сая төгрөгийн 15 ТАХ-г нэмж тодотгон баталсан байна.

Замын-Үүд сумын ИТХ-ын 2018 оны 10/09 дүгээр тогтоолоор 2019 онд нийт 1322.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 ТАХ хэрэгжүүлэхээр баталсан. 2019 оны 12/02 тогтоолоор 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нэг ТАХ-г хасаж, 94.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТАХ нэмж хэрэгжүүлэхээр тодотгон баталснаар нийт 1367.5 төгрөгийн төсөвт өртөгтэй 21 ТАХ-г сумын төсвийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэхээр болсон байна.

Эрсдлийн үнэлгээ: Урьдчилсан судалгааны явцад хийсэн дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг “дунд” гэж үнэлэв.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхэд ТХШС, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах, холбогдох байгууллага, албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт: Дараах хууль эрхийн акт, бодлогын бичиг баримтыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашигласан:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Иргэний хууль,
- Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоол, холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд.
- ИТХ-ын 2019 оны төсөв баталсан тогтоолууд

Аудит хийх хугацаа: Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 13-нд эхэлж, 2020 оны 04 дүгээр сарын 27-ны дотор тайланг хяналтаар оруулан дуусгаж, аймгийн ИТХ болон холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн: Аудитыг Дорноговь аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Ариунаа удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Ч.Хэрлэнчимэг хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Лүндэгмаа, аудитор П.Энхбаяр нар гүйцэтгэв.

Бүлэг 1

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт хууль, журмын дагуу үндэслэлтэй хийгдээгүй байна.

1.1. Аймгийн хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт хуулийн шаардлагад нийцэхгүй байна.

1.1.1. Батлагдсан ТАХ-ний 40-50 гаруй хувь нь аймаг, сумын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй байна.

Аймаг 2019 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 13079.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 81 ТАХ-нд 9032.7 сая төгрөгийн санхүүжилт олгохоор аймгийн ИТХ-аар батлуулсан, мөн Замын-Үүд сум 1367.5 сая төгрөгийн 21 ТАХ-нд 1080.2 сая төгрөгийн санхүүжилт олгохоор сумын ИТХ-аар батлуулсан байна.

	Үзүүлэлт	Тоо хэмжээ	Төсөвт өртөг /сая төгрөг/	2019 онд санхүүжүүлэх дүн /сая төгрөг/	Тоо хэмжээ	Төсөвт өртөг /сая төгрөг/	2019 онд санхүүжүүлэх дүн /сая төгрөг/
1	АИТХ-ын 2018.12.03-ны өдрийн 9/08 тогтоол				СИТХ-ын 2018.12.07-ны өдрийн 10/09 тогтоол		
	Хөрөнгө оруулалт	56	11,224.0	7,717.8	13	1,322.8	1,035.5
	Замын сан	10	1,272.9	642.4			
	Анхны батлагдсан дүн	66	12,496.9	8,360.2	13	1,322.8	1,035.5
2	АИТХ-ын 2019.06.10-ны өдрийн 11/09 тогтоол				СИТХ-ын 2019.12.09-ний өдрийн 12/02 тогтоол		
	Баталсан төсвийг нэмэгдүүлсэн			90.0			
	Шинээр нэмж баталсан	15	582.5	582.5	9	94.7	94.7
	Баталсан төсвийг хасаж өөрчилсөн	-	-	-	1	50.0	50.0
	Тодотгосон дүн	15	582.5	672.5	8	44.7	44.7
3	2019 оны батлагдсан дүн	81	13,079.4	9,032.7	21	1,367.5	1,080.2

Аймаг, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд нийт 14,446.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 102 ТАХ-нд 10,112.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төсөв батлагдсан байна.

Замын-Үүд сум хөрөнгө оруулалтын төсөвт тодотгол хийхдээ сумын ИТХ-ын анхны тогтоолоор баталсан дүнгээс ХАА-ны гэрээ байгуулсан төсвийн хэмнэлтээр шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний дүнг тогтоолын хавсралтад зөрүүтэйгээр тооцсон байв. Тухайлбал тогтоолын дүн 1080.2 сая төгрөг байхад жагсаалтын дүн/ санхүүжүүлэх дүн/ 1061.9 сая төгрөг буюу 18.0 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө төрөөс баримталж буй МУ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилтод нийцүүлж харьцуулсан судалгаа хийгээгүй, аймгийн ИТХ-ын шийдвэр бүхий орон нутагт хэрэгжүүлэх тэргүүлэх ач

холбогдол бүхий хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, түүний үр ашгийн тооцоо байхгүй байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх ТАХ Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт бүрэн тусгагдсан байна. Харин тайлант онд шинээр хэрэгжүүлэх 66 ТАХ-ний 38 нь буюу 57.5 хувь нь үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээ байна.

Замын-Үүд сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2019 оны үндсэн чиглэлд хөрөнгө оруулалт, дэд бүтцийн 5 зорилт тусгагдсан бөгөөд ИТХ-аас баталсан хөрөнгө оруулалтын 21 ТАХ-ний 76.2 хувь буюу 16 ТАХ нь үндсэн чиглэлд тусгагдаагүй байна.

Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг нарийвчилж судалсан, тэргүүлэх ач холбогдлоор, зориулалт, шинж чанараар ангилсан баримт материалыг боловсруулж гаргаагүй, үр ашгийн тооцоо судалгааг хийгээгүйгээс үндсэн чиглэл болон хэрэгжүүлэх ТАХ-г бодитой төлөвлөх нөхцөл бүрдэхгүйд хүргэжээ.

1.1.2. Хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө хэрэгцээ шаардлагаа тодорхойлоогүй, хуулийн шаардлагыг баримтлаагүй байна.

Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-д хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө тухайн салбарын бодлого чиглэл, хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэргийг судлан холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байх, хэрэгцээ шаардлагыг хүн ам, өрхийн тоо, газар нутгийн байршил, барилга, байгууламжийн хүчин чадал, ашиглалтын зардал, хөрөнгө оруулалтын үр өгөөж зэргийг харьцуулан судлахаар заасан байна.

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтэс нь хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлийг хангуулах чиг үүрэгтэй ажилладаг бөгөөд аудитын явцад хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үйл явцтай холбоотой судалгаа, тайлбар, тодруулга авсан.

Гэтэл хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, хөрөнгө бий болсноос хойш гарах урсгал зардал, санхүүжүүлэх эх үүсвэр зэргийг тооцож судлаагүйгээр 2663.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ /иргэдийн хөгжлийн төв, багийн төвийн барилга, ахуйн үйлчилгээний төв, орон сууцны барилга/-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Мөн барилгын их засварын ажлын хэрэгцээ шаардлага, барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлт зэргийг үндэслээгүй 1037.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 их засварын ажлыг төлөвлөсөн байна. **Хавсралт 1-д харуулав.**

1.2. ИТХ-аас хуулийн заалтыг зөрчиж төсөл арга хэмжээний төсөв баталснаас орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, үр дүн хангалтгүй байна.

1.2.1. Нэр, байршил тодорхойлоогүй ТАХ-нд төсөв баталсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2019 онд байршил тодорхойгүй 43.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Саравч, сүүдрэвч, сандал, гадна тохижилтыг сайжруулах” нэртэй ажил баталсан байна. Энэ нь хаана, хэдийг суурилуулах нь тодорхойгүй байна. Мөн Хуучин орон сууцны барилгуудын дээвэр, дулаалга, гадна фасадны засварын ажил нэрээр 600.0 сая төгрөг баталсан нь хаана байрлах хэдэн орон сууцыг засварлах нь тодорхойгүй байна.

Нэр, байршил тодорхойгүй байгаа нь төлөвлөсөн ажил хугацаандаа хэрэгжиж дуусахгүй, ашиглалтгүй байх зэргээр хөрөнгө оруулалтын үр дүнд нөлөөлж байна.

1.2.2. Зураг төсөвгүй, газрын зөвшөөрөлгүй, техникийн нөхцөл гараагүй ТАХ-г баталсан уу

1.2.2. ИТХ-аас зураг төсөвгүй, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл гараагүй ТАХ-нд төсөв баталсан байна.

Төсвийн тухай хуульд техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхээр тусгасан байдаг.

Аймгийн ИТХ-ын 2018.12.03-ны өдрийн 9/08 дугаар тогтоолоор нийт 1532.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ-ны зураг төсөвгүй, 290.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ газрын зөвшөөрөлгүй байхад төсөв баталсан байна.

ТАХ-ний нэр		/сая төгрөг/ Төсөвт өртөг
Зураг төсөвгүй ТАХ		
1	Өргөн сумын ундны усны нөөцийн савыг шинэчлэх	50.0
2	Даланжаргалан суманд ахуй үйлчилгээний төв барих	150.0
3	Замын-Үүд суманд Халуун усны барилга барих	114.7
4	Дэлгэрэх суманд Төрийн албан хаагчийн 4 айлын орон сууц барих	140.0
5	Аймгийн төвийн болон зарим сумдын сургууль, цэцэрлэг, эмнэлгийн хашаанд саравч, сүүдрэвч, сандал хийж гадна тохижилтыг сайжруулах /29*1500,0/	43.5
6	Даланжаргалан суманд Багийн төв барих	58.5
7	Сайншанд сумын Хуучин орон сууцны барилгуудын дээвэр, дулаалга, гадна фасадны засварын ажил	600.0
8	11-р цэцэрлэгийн баруун талд авто зогсоол барих	43.20
9	Сайншанд сумын 2, 3, 6-р багийн авто зам дагуу гэрэлтүүлэг хийх	175.0
10	Тохижилт Сайншанд хот тохижилтын газрын авто гаражийн барилгын	158,0
Газрын зөвшөөрөл олгогдоогүй ТАХ		
1	Даланжаргалан суманд ахуй үйлчилгээний төв барих	150.0
2	Дэлгэрэх суманд Төрийн албан хаагчийн 4 айлын орон сууц барих	140.0

Зураг төсөв батлагдаагүй ТАХ-г төлөвлөснөөр ХАА зохион байгуулах, шинээр зураг, төсөв боловсруулахад тодорхой хугацаа шаардагдаж, хөрөнгө оруулалтын ажлууд төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй он дамжихад хүргэж байна.

Сайншанд сумын 4, 7 дугаар багийн малчдын бэлчээрийг усжуулахад зориулж усны хайгуулын судалгаа хийлгүй инженерийн хийцтэй 1 худаг гаргахаар төлөвлөсөн нь үр дүнгүй байна. Энэ ажилд 24.3 сая төгрөгийн төсөв баталсан бөгөөд Эхний эхэн ХХК-тай 2019.05.10-2019.05.25-ны хооронд гүйцэтгэх, 2019.12.01 хүртэл хугацааг сунгах гэрээг тус тус байгуулсан байна. Худаг гаргахаар 2 цэгт өрөмдлөг хийсэн ч ус гараагүйгээс хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх худаг ус бий болгох ажил үр дүнгүй болсон, усны хайгуулыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгох, өрөмдлөгийн тоног төхөөрөмжөө солих шаардлагатай болсон байна.

1.2.3. Аймаг, сумын төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан байна.

Төсвийн тухай хуулийн заалтыг¹ зөрчиж тухайн шатны төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй хөрөнгө оруулалтад аймаг 240.0 сая төгрөг, Замын-Үүд сум хөрөнгө оруулалтын зардлын 50 гаруй хувь буюу 541.0 сая төгрөгийн ТАХ төлөвлөж, ИТХ-аар батлуулжээ.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар:

- Онцгой байдлын газарт автомашин худалдан авах 60.0 сая төгрөг,
- Прокурорын газрын барилгын дотор засварын ажил 30.0 сая төгрөг
- Хилийн 0108-р ангийн 12 айлын орон сууцны барилга барихад дэмжлэг үзүүлэх 50.0 сая төгрөг
- Хилийн 0129-р ангийн 6, 7-р заставыг өндөр хүчдэлийн шугамд холбох ажилд дэмжлэг үзүүлэх /Эрдэнэ/ 50.0 сая төгрөг
- Хилийн 0168-р ангийн хилийн харуулын байр барих ажилд дэмжлэг үзүүлэх /Хатанбулаг/ 50.0 сая төгрөг

Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар:

- ГИХГ-ын албан хэрэгцээнд суудлын автомашин худалдан авах 200.0 сая төгрөг,
- ГИХГ-ын албан хэрэгцээнд 8 хүний суудалтай автомашин худалдан авах 82.0 сая төгрөг
- ГИХГ-ын албан хэрэгцээнд суудлын автомашин 2 ширхгийг худалдан авах 151.0 сая төгрөг
- ГИХГ-ын дотоод сүлжээний серверийн шинэчлэлтийн ажил хийх 67.0 сая төгрөг
- Сум дундын цагдаагийн хэлтсийн албан конторын дээврийн засварын ажил 10.0 сая төгрөг
- Нэгдсэн эмнэлэгт тоног төхөөрөмж худалдан авах 16.0 сая төгрөг
- Цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх байрны засварын ажил 15.0 сая төгрөг

Төсвийн тухай хуулийн 58.2.3-т аймаг өөрийн төсвөөр “орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх” гэж заасныг зөрчиж хөрөнгө оруулалтын бус зардалд аймаг 75.0 сая төгрөгийн төсөв баталсан байна.

- Хатанбулаг сумын 100 жилийн ойд зориулсан теле бичлэг хийх ажил 15.0 сая төгрөг,
- Эрдэнэ сумын түүхийг харуулсан зурагт альбом хийх ажил 10.0 сая төгрөг,
- Зүүнбаян Нефтийн үйлдвэрийн 70 жилийн ойд зориулсан зурагт сэтгүүл хэвлүүлэх ажил 10.0 сая төгрөг,
- Дорноговь аймгийн түүхэн баримтат кино хийх ажил 40.0 сая төгрөг

¹Төсвийн тухай хуулийн 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”, Төсвийн тухай хуулийн 4.1.24 дэх “хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг” хэлнэ

Бүлэг 2

Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг сайжруулж үр нөлөөг дээшлүүлэх хэрэгтэй байна.

2.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааны үр дүнг сайжруулах шаардлагатай байна.

2.1.1. ХАА-г зохион байгуулах төлөвлөсөн хугацаа хэтэрсэн, ТББ-т хуульд заасан шаардлагуудыг бүрэн тусгаагүй, хүчин чадлын үзүүлэлт, үнэ ханш, эдийн засгийн үр ашигт байдлыг тооцож техникийн тодорхойлолт боловсруулаагүй байна.

Аймгийн төсвийн ХО-аар 2019 онд санхүүжүүлэх 81 ТАХ-ний 10 нь өмнөх онд ХАА зохион байгуулагдсан тул 71 ТАХ-нд /эрх шилжүүлсэн 12 ТАХ орсон/ ХАА зохион байгуулахаар, Замын-Үүд сум 18 ТАХ-нд ХАА зохион байгуулж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

	Үзүүлэлт	НТШ	ХА	ЗҮ	ШГ	Нийт дүн
1	Аймгийн ОНӨГ-аас болон эрх шилжүүлсэн байгууллагын ХАА	27	34	5	5	71
2	Замын-Үүд сумын ЗАА-аас зохион байгуулсан ХАА	7	6		5	18

Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, ТББ боловсруулах, тендер хүлээн авах, нээх ажиллагааг зааврын дагуу гүйцэтгэх, тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх эрх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр болон ОНХС, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх зэрэг эх үүсвэрээр 2019 онд хэрэгжүүлэх ТАХ-ний тоо олон, барилгын компаниудын гэрээт ажлын хугацаа давхцах, тендерт шалгаруулалтад оролцогч ирэхгүй байх, тендер дахин зарлах зэргээс 2019 онд худалдан авах бараа, ажил үйлчилгээний ХАА-нд мөрдөх үнэлгээний хороо байгуулах, тендер зарлах, гэрээ байгуулах эрх олгох, гэрээ дуусгавар болох, дүгнэх хугацаа хэтэрсэн байна.

	Үзүүлэлт	Аймаг		Замын-Үүд сум	
		ТАХ-ний тоо	Хугацаа	ТАХ-ний тоо	Хугацаа
1	Үнэлгээний хороо байгуулах хугацаа хоцроосон	14	3-30 хоног	9	14-30 хоног
2	Тендер зарлах хугацааг хоцроосон	22	15-90 хоног	8	8-90 хоног
		2	150-300 хоног	1	150 хоног
3	Хугацаандаа гэрээ байгуулах эрх олгосон	11	0	2	0
	Гэрээ байгуулах эрх олгох хугацааг хоцроосон	37	30-90 хоног	8	7-45 хоног
		6	90-180 хоног	2	90 -96 хоног
		4	180 хоногоос дээш	2	240-270 хоног
4	Гэрээ дуусгавар болох, дүгнэх хугацааг хоцроосон	36	10-180 хоног	7	30-90 хоног
		5	180-300 хоног	4	90-300 хоног

Тендерт оролцогч ирээгүй, шаардлага хангасан тендер ирүүлээгүй шалтгаанаар НТШ-аар зарласан 10 ТАХ, ХА-аар зарласан 5 ТАХ-нд тус тус шууд гэрээ байгуулсан байна.

Дээрх байдлуудаас шалтгаалж хөрөнгө оруулалтаар бий болох бараа, ажил үйлчилгээ, барилга, засварын ажил, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь ашиглагч, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг зорилтот хугацаанд хангаж чадахгүй байдалд хүрч, хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулж байна.

Ажлын тоо хэмжээ ирээгүй шалтгаанаар тендер зарлах төлөвлөсөн хугацааг хэтрүүлж зарласан, тендер зарласан хугацаанд оролцогч ирээгүйгээс дахин тендер зарлах, шууд гэрээ байгуулах урилга хүргүүлсэн компаниуд тендерт оролцох саналаа ирүүлэхгүй байх зэргээс ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46.1.8-д “барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх” гэсэн заалт зөрчигдсөн, ТББ-т заасан шалгуур хангаагүй компаниар ажил гүйцэтгүүлэх шийдвэр гаргасан, гүйцэтгэгч ТАХ-г он дамжин хэрэгжүүлэх зэргээр хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулсан үр дагавар бий болж байна. Тодруулбал:

Даланжаргалан суманд ахуй үйлчилгээний төв барих ажилд 2 удаа тендер зарлахад оролцогч ирээгүй байна. Ажлын тоо хэмжээ өндөр, төсөвт өртөгтөө багтахгүй байгаа асуудлыг үнэлгээний хорооны хурлаар хэлэлцсэн, захиалагчаас ажлын тоо хэмжээг багасгах шийдвэрт хүрснийг ОНӨГ-т албан бичгээр мэдэгдсэн байна. Техникийн тодорхойлолтод барилгын хэмжээ 15*9м байсныг 12*9м болгож өөрчилсөн байна. Шууд гэрээ байгуулахаар 3 компанид санал хүргүүлсэн бөгөөд тэдгээр компаниас санал ирээгүй, харин Хибики ХХК-аас үнийн санал ирүүлсэн байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 30.4.2-т “энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах” гэж заасан байтал шууд гэрээ байгуулсан байна. Тус компанид 2019.12.25-нд 70.0 сая төгрөгийн урьдчилгаа олгосон.

Дэлгэрэх суманд төрийн албан хаагчийн байр барих ажлын гүйцэтгэгч Урбан девелопмент консталинг групп ХХК гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүй тул аймгийн ЗД-ын 2019.12.19-ний өдрийн А/920 захирамжаар гэрээг цуцалсан байна. 2019.12.19-нд үнэлгээний хорооноос цаг хугацаа алдсан тул Төгс-Өнөд ХХК-аар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэж шууд гэрээ байгуулсан байна. Тус компани 2019 оны 3 сард үүсгэн байгуулагдсан компани бөгөөд 6 дугаар сард барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл авсан байна. Санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан байх, ижил төстэй ажлыг сүүлийн 2 жилд гүйцэтгэсэн байх гэсэн ТББ-ийн шаардлагад нийцэхгүй байна. 2019.12.25-нд 70.0 сая төгрөгийн урьдчилгаа олгосон.

Хатанбулаг сумын Иргэдийн хөгжлийн төв барих ажлын ТББ-т туслан гүйцэтгэгчээр гүйцэтгэж болох хувь хэмжээг 10-30 хүртэл хувь гэж заасан. Ерөнхий гүйцэтгэгч Шинэ-Өрнөлт трейд ХХК барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлгүй бөгөөд туслан гүйцэтгэгч Сан ХХК тусгай зөвшөөрөлтэй байна. Шинэ-Өрнөлт трейд ХХК-д 2019.12.25-нд 144.2 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгосон.

	ТАХ-ний нэр	ХАА-ны төлөвлөгөөгөөр тендер зарлах хугацаа	Тендер зарласан хугацаа	Шууд байгуулах урилга хүргүүлсэн компани	Гэрээ байгуулсан огноо, компанийн нэр	Гэрээний хугацаа, дүн	Гэрээний сунгалт
1	Даланжаргалан суманд ахуй үйлчилгээний төв барих	2019.03.22-2019.04.22	2019.08.28-2019.09.30, 2019.10.01-2019.10.30	Энержи Парогон, БЭМЭС, Миний Сайншанд ХХК	2019.11.13 Хибикс ХХК	149.5 сая төгрөг 2019.11.13-2019.12.15	2019.12.15-2020.05.01
2	Дэлгэрэх суманд төрийн албан хаагчийн байр барих	2019.03.27-2019.04.27	2019.03.19-2019.04.19 2019.04.19-2019.05.20	Төгс-Өнөд, Миний Сайншанд, Хул шанд ХХК	2019.06.03 Урбан девелопмент консталинг групп ХХК	140.0 сая төгрөг 2019.07.20-2019.09.20	Ажил гүйцэтгээгүй тул гэрээ цуцалсан
				Урилга хүргүүлээгүй,	2019.12.20 Төгс-Өнөд ХХК	139.8 сая төгрөг 2019.12.20-2020.09.01	
3	Хатанбулаг суманд иргэдийн хөгжлийн төв барих	2019.03.27-2019.04.27	2019.10.25-2019.11.25		2019.12.05 Шинэ-Өрнөлт трейд ХХК	245.0 сая төгрөг 2019.12.05-2020.04.01	

Замын-Үүд суманд Борхойн багийн гадна тохижилтын ажлын тендер шалгаруулалтад оролцогч ирээгүйгээс шалтгаалж 6 удаа тендер зохион байгуулсан. Хуртай өргөө ХХК-тай 2019.12.19-нд ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажлыг 2020.05.25-нд дуусгах болсон байна.

ТББ-т хуулиар заасан санхүүгийн болон техникийн шаардлагыг бүрэн тусгаагүй байна. Тухайлбал:

- Санхүүгийн чадавхын шаардлагыг тусгахдаа баталгаажуулсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх, зөвлөхийн орон тоо, цалин, бусад зардлын тооцооны хүснэгт ирүүлэх гэсэн шаардлагыг зарим ТАХ-ний ТББ-т дутуу тусгасан, зарим ТАХ-ний борлуулалтын орлогыг сүүлийн 2 жилийн дундаж , төсөвт өртгийн 20 хувь, 80 хувиас багагүй байх гэж харьцангуй өөр өөр байдлаар тусгасан байна.
- Техникийн чадавхын шаардлагад тухайн гэрээтэй ижил төстэй бараа, ажил үйлчилгээний талаар ихэвчлэн 2 жилийн үзүүлэлтийг шаардсан байна. Тендерт оролцогчийн чанарын хяналтыг шууд, эсхүл туслан гүйцэтгэх гэрээ байгуулах замаар хэрэгжүүлэх чанарын хяналтын арга хэмжээг шаардаагүй байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 11.1.1-д “тухайн бараа, ажил, үйлчилгээг гадаад шинж чанарын үзүүлэлтээр бус, зориулалт, эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээ, ашиглалт, чанарын түвшин, техникийн болон тухайн бараа, ажил, үйлчилгээ нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлох” гэж заасан байдаг. Зарим ТАХ-ний техникийн тодорхойлолт боловсруулахдаа хуулийн энэ заалтыг хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал: АИТХ-аас “Тохижилт Сайншанд” хот тохижилтын газарт авто машин худалдан авах ажилд 20.0 сая төгрөгийн төсөв баталсан. ТББ-т авто машины маркийг прусс 20, үйлдвэрлэгдсэн оныг 2009-2010 он гэж тусгаж өгсөн байна. Прусс 20 маркийн машин зах зээл дээр 12.0-13.0 сая төгрөгийн үнэ ханштай байхад 20.0 сая төгрөгөөр худалдан авсан байна.

Нийтийн тээврийн үйлчилгээнд автобус худалдан авах техникийн тодорхойлолтод үйлдвэрлэсэн оныг 2010 он буюу түүнээс хойш байх гэж тусгасан байна. Нийтийн тээврийн үйлчилгээг өндөр настан, ЕБС-ийн хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд

ихэвчлэн авдаг. Хүүхэд тээвэрлэх автобус үйлчилгээнд тавих шаардлага MNS6440:2014 стандарт-ын 5.1.3-т “Үйлдвэрлэснээс хойш 10-аас дээш жил ашигласан тээврийн хэрэгслийг ашиглахыг хориглоно” гэж заасан байна.

Чандмань-Илч ХХК-д авто парк шинэчлэлтийн 250.0 сая төгрөгийн ажлын ХАА-ны эрхийг шилжүүлсэн байна. Тус компани 4 нэр төрлийн авто техник худалдан авахдаа 4 багц болгон 2 удаа тендер зарлаад оролцогч ирээгүй тул шууд худалдан авах гэрээ байгуулсан байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46.1.4-т “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах” гэж заасан. Чандмань-Илч ОНӨХХК ХАА зохион явуулахдаа батлагдсан төсөвт багтаагаагүй, гаалийн бүрдүүлэлттэй холбоотой зардлыг байгууллагаас гаргаж худалдан авалт хийн бүртгэлд тусгасан байна.

	Хөрөнгийн нэр төрөл	Нийлүүлэгч	Гэрээний үнэ	Хөрөнгийн бүртгэлийн үнэ	Тайлбар
1	Хүнд даацын өөрөө буулгагч шаланз авто машин /багц 1/	Bei long компани	153.4	115.6	Шаланз маркийн чирэгч автомашины техникийн тодорхойлолтод 2018 оны шинэ автомашин, чиргүүлийн ачааны даацыг 60 тонн-оос доошгүй гэж заасан ч 2017 оны 50 тонны даацтай автомашин худалдаж авсан. Худалдах, худалдан авах гэрээнд гаальтай холбоотой зардлыг худалдан авагч тал хариуцна гэж заасан.
	Өөрөө буулгагч чиргүүл /багц 1/	Bei long компани		59.2	
2	Дугуйт ачигч /багц 2/	Wang long компани	23.6	26.3	КАМА маркийн автомашины техникийн тодорхойлолтод 5995 кг-аас дээш даацтай гэж заагдсан ч 5 тонны КАМА худалдаж авсан. Хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрт төлбөр тооцоотой холбоотой асуудлыг худалдан авагч тал бүрэн хариуцна гэж тусгасан.
3	Өөрөө буулгагч Кама машин /багц-4/	Wang long компани	23.6	26.5	
4	Solar 55 v эксковатор /багц 3/	Илт орд ХХК	49.4	49.4	
	Дүн		250.0	277.0	

ТАХ-ний хүчин чадлын үзүүлэлт, үнэ ханш, эдийн засгийн үр ашигт байдал, хэрэглээ, ашиглалтын үзүүлэлтийг сайн судалж техникийн тодорхойлолтыг боловсруулаагүйгээс эдийн засгийн үр ашиггүй, хөрөнгийн ашиглагдах хугацаа дууссан үзүүлэлтийг техникийн тодорхойлолтод тусгасан байна.

ХАА-ны хуулиар 150 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ажил, 100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах эрх олгохдоо гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг гүйцэтгэгчээс шаардана гэсэн байдаг.

Аймгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх ТАХ-ний ТББ-т гүйцэтгэлийн баталгаа шаардах 16 ТАХ байгаагаас Чандмань-Илч ХХК-д эрх шилжүүлсэн 1 ТАХ байна. ОНӨГ-аас 4 ТАХ-ний ТББ-т гүйцэтгэлийн баталгаа шаардаагүй байна. Замын-Үүд сумын ХАА-ны ТББ-т гүйцэтгэлийн баталгаа шаардах 5 ТАХ байснаас суудлын авто машин худалдан авах 2 ТАХ-нд гүйцэтгэлийн баталгаа шаардаагүй байна.

Гэрээ байгуулах эрх олгогдсон ТАХ-ний гүйцэтгэлийн баталгаа байршуулбал зохих дүн аймагт 279.6 сая төгрөг, Замын-Үүд суманд 46.7 сая төгрөг байхад нэг ч гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгаа байршуулаагүй байна. /хавсралт 2-т харуулав/

				/Сая төгрөгөөр/			
				Гэрээ байгуулах эрх олгосон	Гэрээний дүн	Гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх дүн	Байршуулсан тендерийн баталгааны дүн
1	Аймгийн оруулалт	төсвийн	хөрөнгө	16	5591.4	279.6	68.4
2	Сумын оруулалт	төсвийн	хөрөнгө	5	934.6	46.7	19.0
	Нийт дүн			21	6526.0	326.3	87.4

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 20.7.2-т “«хамгийн сайн» үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдэлд заасан хугацаанд гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй, эсхүл гэрээ байгуулахаас татгалзсан” тохиолдолд тендерийн баталгааг улсын орлого болгоно гэж заасан. Гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй гүйцэтгэгчийн нийт 87.4 сая төгрөгийн тендерийн баталгааг улсын орлого болгоогүй байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 40.3.3-т “урьдчилгаа төлбөр хийх бол урьдчилгаа төлбөрийн баталгааны дүн, хэлбэр”-ийг худалдан авах гэрээнд заавал тусгана. Мөн хуулийн 44.4-т “Тендерийн баримт бичигт заагаагүй тохиолдолд захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй” гэж заасан байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих, тайлант хугацаанд хэрэгжиж дуусаагүй 8 ТАХ-ний ГТН-д урьдчилгаа төлбөрийн баталгаа шаардаагүй байтал гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд 30-50 хувийг гэрээ байгуулснаар олгоно гэж тусгасны дагуу санхүүжилт олгосон байна.

Замын-Үүд сумын ЗАА зарим ТАХ-ний ТББ-т худалдан авах ажиллагаанд урьдчилгаа төлбөр төлөх эсэхийг тусгаагүй байна. Тухайлбал: Замын-Үүд дэх сум дундын Цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх байрны засвар, албан хэрэгцээнд авто машин худалдан авах, цэвэр усны шугам өргөтгөх, Борхойн багийн гадна тохижилтын ажил зэрэгт урьдчилгаа төлбөр төлөх талаар ГТН-д тусгаагүй байна. Хуулийн дээрх заалтыг зөрчиж гэрээнд урьдчилгаа төлбөр төлөхөөр тусгасан, эдгээр ажлуудаас цэвэр усны шугам өргөтгөх ажлаас бусад ажлын гэрээний үнийн дүнгээр гэрээ байгуулсан өдөр санхүүжилт олгосон байна. /Хавсралт-9/

Засгийн газрын 2012 оны 115 дугаар тогтоолоор баталсан Худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих журмын 5.4-т “Мэргэжлийн байгууллага энэхүү журмын 3.4-т заасан гүйцэтгэлийн мэдээллийг нэгтгэн дүн шинжилгээ хийж холбогдох арга хэмжээг авч ажиллана” гэж заасан. ОНӨГ болон Замын-Үүд сумын ЗАА дээрх заалтын дагуу тендерт шалгарсан оролцогчдын гэрээний хэрэгжилтийн явц, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасны дагуу төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа эсэх, санхүүжилт хийгдсэн мэдээлэл, бусад шаардлагатай мэдээллийг авч нэгтгэн дүн шинжилгээ хийгээгүй байна.

2.1.2. Зарим ТАХ-ний хуулийн шаардлагад нийцээгүй оролцогчийг тендерт шалгаруулсан байна.

Тендерт оролцогчоос захиалагч болон Сангийн яаманд гомдол гарсан байна. Тухайлбал: **Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Гемодиализын аппарат нийлүүлэгчийг сонгон шалгаруулах** явцад Айвико интернешнл ХХК-аас аймгийн ЗДТГ-т гомдол гаргасан байна. Сангийн яамнаас гомдолд дурдсан тендер шалгаруулалтын ажиллагааг хууль, холбогдох дүрэм журамд нийцсэн эсэхийг хянаж тендерийг түр түдгэлзүүлсэн байна. Нарт эрдэнэс ХХК техникийн тодорхойлолтод заасан

шалгуурыг хангаагүй байхад шаардлагад нийцсэн гэж үнэлсэн нь хуулийн 27.3 дахь заалттай нийцээгүй болохыг тодорхойлж тендер шалгаруулалтын үнэлгээг дахин хийх гэсэн дүгнэлт ирүүлсэн байна.

Мөн Нарт-эрдэнэс ХХК-аас ОНӨГ-т хугацаа хэтэрсэн зээлийн өргүй талаарх тодорхойлолт хүргүүлсэн байхад шаардлага хангаагүй гэж үнэлсэн үнэлгээний хорооны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа тухай гомдол гаргасан бөгөөд Сангийн яамнаас гомдлыг хянаж худалдан авах ажиллагааг хуулийн дагуу үргэлжлүүлэхийг мэдэгдсэн байна.

Дорноговь аймгийн түүхэн баримтат кино хийх ажлын тендер ТАКТ интертаймент ХХК 35.0 сая төгрөг, Үүлэн зардас ХХК 39.9 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн байна. ТББ-т санхүүгийн чадавхын үзүүлэлтээр өргүй байх, НД-ын тайлан НД 7, НД 8 маягтаар гаргасан тайлан ирүүлэхийг шаардсан.

Үнэлгээгээр Такт интертаймент ХХК татварын өртэй, ижил төстэй ажил гүйцэтгэснийг нотлох баримт, гэрээ ирүүлсэн боловч ажил хүлээн авсан акт ирүүлээгүй, бусад шаардлага хангасан байна. Үүлэн зардас ХХК Нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлээгүй, шимтгэл төлдөггүй гэсэн тодорхойлолт ирүүлсэн байна. Өндөр үнийн санал ирүүлсэн Үүлэн зардас ХХК-ийг тендерийн бүх шаардлагыг хангасан гэж үнэлж тендерт шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 14.1-д “Дараах нөхцөл байдал тогтоогдвол тендерт оролцогч ерөнхий нөхцөл хангаагүй гэж үзнэ”, 14.1.2-т “Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй” гэж заасныг зөрчиж байна.

Аймгийн ЗДТГ-ын их засварын ажлын тендер ЭМ ТИ ЭМ Жи ХХК шалгарч 104.0 сая төгрөгөөр гүйцэтгэх гэрээ байгуулсан байна. ИТХ-аас баталсан төсвийн дүнгээс хэтрүүлж тус компанитай 14.2 сая төгрөгийн засварын ажил гүйцэтгэх нэмэлт гэрээ байгуулсан байв. Компанийн ирүүлсэн тендерийн материалд өөрийн эзэмшлийн 1 авто машин Хас банкны нэр дээр байх, төсвийг ГХБХБГ-аар хянуулахад ажлын тоо хэмжээ, нэмэгдэл зардлыг дутуу тооцож ирүүлсэнд ОНӨГ тодруулга авсан байна.

Сант номун ХХК барилгын засварын ажлын явцад зохиогчийн хяналт тавьж, Эм ТИ Эм Жи ХХК ажлаа чанартай гүйцэтгэхгүй, мэргэжлийн ур чадваргүй байгаа асуудлыг АЗДТГ-т тавьж хуралдсанаар гэрээг цуцлахаар болсон байна. Үнэлгээний хорооны 2019.05.21-ний өдрийн хуралдаанаар Төгс-Өнөд ХХК-аар ЗДТГ-ын засварын хийгдээгүй үлдсэн ажлыг 64.4 сая төгрөгөөр гүйцэтгүүлэх дүгнэлт гаргаж, гэрээ байгуулсан байна.

Улаанбадрах сумын төвлөрсөн шугам сүлжээний цэвэр усны шугамын угсралтын 789.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын тендер Б Софт ХХК 689.0 сая төгрөг, түншлэлээр Сизу ХХК, Гом-Илч ХХК-ууд 720.2 сая төгрөгийн үнийн санал ирүүлж шаардлагад нийцсэн байна. Түргэн хөрвөх хөрөнгийн чадавхын үзүүлэлтийг ТББ-т төсөвт өртгийн 80 хувь гэж тусгасан бөгөөд Б.Софт ХХК харилцах дансандаа 770.0 сая төгрөгтэй байгаа нь шаардлагыг хангасан, Сизу, Гом-Илч 2 ХХК-ийн дансны үлдэгдэл нийлээд 338.4 сая төгрөг буюу шаардлага хангаагүй байхад зээл авах боломжтой гэсэн үзүүлэлтээр Гом-Илч ХХК-ыг шаардлага хангасан гэж үнэлсэн байна. ХАА-ны хуулийн 28.3-т “Шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх үндсэн шалгуур нь тендерийн үнэ байна” гэснийг зөрчиж илүү үнийн санал ирүүлсэн Гом-Илч ХХК-ийг тендерт шалгаруулсан байна.

2.2. Гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй байна.

2.2.1. Гүйцэтгэгчийн хариуцлагагүй үйл ажиллагаанаас ТАХ хугацаандаа хэрэгжиж дуусаагүй, хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулсан байна.

Тендерт оролцогч гэрээний тусгай нөхцөлд заасан ажил эхлэх, дуусах хугацааг хүлээн зөвшөөрч гүйцэтгэх ажлын үе шатны төлөвлөгөө гаргадаг. Мөн захиалагчтай байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний 6-р заалтад “Энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно” гэсэн заалтыг бүрэн зөвшөөрч гарын үсэг зурж баталгаажуулдаг. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх бүх ТАХ 2019 онд хэрэгжиж дуусах байтал гүйцэтгэгч тендерт ирүүлсэн ажиллах хүч, машин техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлаа бүрэн ашиглахгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй, гэрээний хугацааг хэтрүүлсэн, сунгасан, өнөөг хүртэл ажлаа дуусгаж актаар хүлээлгэн өгөөгүй, урьдчилгаа хэлбэрээр болон 100 хувь санхүүжилт авсан 13 ТАХ байна. Эдгээрээс дуусаагүй бөгөөд 1211.9 сая төгрөгийн санхүүжилт авсан ТАХ-г тодруулбал:

- Урбан девелопмент консалтинг ХХК Дэлгэрэх суманд Төрийн албан хаагчийн 4 айлын орон сууц барих ажил 2019.09.20-нд ажил дуусах байсан ч дуусгаагүй, дараагийн гүйцэтгэгч Төгс-Өнөд ХХК-д /гэрээний дүн 139.8/ одоогийн байдлаар барилгын суурийн ажил ч хийгдээгүй байхад 70.0 сая төгрөгийн урьдчилгаа олгож, гэрээний дүнгээс 69.8 сая төгрөг үлдсэн,
- Эхний-Эхэн ХХК Сайншанд сумын 4, 7 дугаар багт инженерийн хийцтэй худаг гаргах ажил гэрээний дүн 24.3 сая төгрөг, 2019.05.15-нд дуусах байтал өрөмдсөн газарт ус гараагүй, санхүүжүүлэх 24.3 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан,
- Турникет Монголия ХХК Сайншанд сумын 2 дугаар сургууль, Замын-Үүд сумын 2 дугаар сургуульд турникет систем суурилуулах ажил гэрээний дүн 39.0 сая төгрөг, 2019 онд санхүүжүүлэх дүн 30.8 сая төгрөг, 2019.07.20-нд дуусах байсан ч программ хангамжийн ажил огт хийгдээгүй, 15.6 сая төгрөгийн санхүүжилт олгож гэрээний дүнгээс үлдсэн 15.2 сая төгрөгийг барьцаа дансанд байршуулсан,
- Хибики ХХК Даланжаргалан суманд ахуй үйлчилгээний төв барих ажил гэрээний дүн 149.6 сая төгрөг, 2019 онд санхүүжих дүн 100.0 сая төгрөг, 2019.12.15-нд дуусах хугацаатай ч өнөөг хүртэл ашиглалтад ороогүй, 100.0 сая төгрөг олгосон,
- Хур шанд ХХК аймгийн төвийн болон зарим сумдын сургууль, цэцэрлэг, эмнэлгийн хашаанд саравч, сүүдрэвч, сандал хийж гадна тохижилтыг сайжруулах ажил гэрээний дүн 43.2 сая төгрөг, 2019.11.20-нд дуусах байсан ч суурилуулагдаагүй, 22.3 сая төгрөгийн санхүүжилт олгож үлдэх 20.8 сая төгрөгийг барьцаа дансанд байршуулсан,
- Синко ХХК Эрдэнэ суманд төрийн албан хаагчийн албан тушаалын байр худалдан авах 2-р багцын ажил гэрээний дүн 133.0 сая төгрөг, 2019.11.25-нд дуусах байсан ч барилга ашиглалтад ороогүй, 133.0 сая төгрөгийг бүрэн олгосон,
- Үүлэн зардас ХХК Дорноговь аймгийн түүхэн баримтат кино хийх ажил гэрээний дүн 39.9 сая төгрөг, 2019.10.01-нд дуусах байсан ч ажил дуусаагүй, 39.9 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон,
- Алтайн газрын хүч ХХК Сайншанд сумын Зүүнбаян баг, Өргөн, Иххэт, Айраг сумдад бохир ус шингээх байгууламж шинээр барих зураг төсөв боловсруулах

ажил гэрээний дүн 41.9 сая төгрөг, 2019.08.20-нд дуусах байсан ч өнөөг хүртэл комисс хүлээн аваагүй, 41.9 сая төгрөгийн санхүүжилт бүрэн олгосон,

- Гом-Илч ХХК Улаанбадрах сумын цэвэр усны шугам сүлжээний ажил гэрээний дүн 720.0 сая төгрөг 2019.07.15-нд дуусах байсан ч ажил дуусаагүй, магадлалгүй ажлын зардлын хамт 714.0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгож, зохиогчийн хяналтын зардал 6.2 төгрөг үлдсэн байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, ХАА, гүйцэтгэгчийн хариуцлагагүй үйл ажиллагаанаас ТАХ хугацаандаа хэрэгжиж дуусаагүй, хөрөнгө оруулалтын үр ашиг нь гараагүй, тухайлбал иргэдийн амьдрах, амрах ая тухтай байдал, төрийн албан хаагчид болон малчид, ажилчид, аймаг, сум орон нутгийн хэрэгцээ шаардлага хангагдаагүй байна.

Дуусаагүй ТАХ-г дуусгах, гэрээний хугацаа хэтрүүлсэн зөрчлийг арилгуулахаар аймгийн ХОХБТХ-т хариуцуулж нэг албан шаардлага өглөө.

2.2.2. Барилгыг ашиглалтад оруулахад нөлөөлөх хүчин зүйл байгаа эсэхийг хэлэлцэж дүгнэх ажил хангалтгүй байна.

Барилгын ажлын гүйцэтгэлийг зохиогчийн болон захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлттэй уялдуулан хянах, ашиглалтад оруулахад нөлөөлөх хүчин зүйл байгаа эсэхийг хэлэлцэж дүгнэх ажил хангалтгүй байна. Ашиглалтад хүлээн авсан зарим барилга байгууламж гадна инженерийн дэд бүтэц шийдэгдээгүйгээс цаашид ашиглах боломжгүй байдал үүссэн байна. Тухайлбал:

- **Замын-Үүд суманд Халуун усны барилга барих ажил:** Барилга байгууламж ашиглалтад оруулах комисс 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн ажиллаж, 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн УКД-54/2019 тоот актаар тус барилгыг ашиглалтад хүлээн авсан байна. Гүйцэтгэгч барилгын гадна инженерийн шугам сүлжээг зураг төсөлд заасан худагт холболт хийсэн боловч уг худагт дулааны эх үүсвэрийн шугам байхгүйгээс шалтгаалж барилгыг ашиглах боломжгүй болсон байна.

2.3. Хөрөнгө оруулалтын дотоод хяналтыг бий болгож, ажлын бодит гүйцэтгэл, санхүүжилтэд тавих захиалагчийн хяналтыг сайжруулах хэрэгтэй байна.

2.3.1. ТАХ-ний үе шат бүрд хяналт тавигдах нөхцөлийг бүрдүүлэх, үе шатны хяналтыг хэрэгжүүлж хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн чанар, үр өгөөжийг сайжруулах шаардлагатай байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журамд “Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын ТАХ-ний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна” гэж заасан байдаг.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 26 ТАХ-ний барилгын үе шатны ажилд хяналт тавихаар ерөнхий захиалагч аймгийн ЗДТГ, захиалагч ГХБХБГ, Замын-Үүд сумын замын 4 ажилд захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээг ЗАА, ГХБХБГ-ын хооронд тус тус байгуулсан байна. Дийлэнх ТАХ-ний техник хяналтын зардлын санхүүжилтийн 70 хувийг ГХБХБГ, 30 хувийг АЗДТГ, Замын-үүд сумын ЗАА авахаар тохиролцсон байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-ний захиалагчийн техник хяналтын зардалд 104,4 сая төгрөг зарцуулснаас ГХБХБГ 68,3 сая төгрөг, аймгийн ЗДТГ 36,1 сая төгрөгийн санхүүжилт, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 4 ТАХ-ний ЗХЗ 11.4 сая төгрөгийн санхүүжилтийг ГХБХБГ авсан байна.

ГХБХБГ нь техник хяналтын зардлын санхүүжилтийн орлогоос Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт төлөвлөгөөний дагуу 30.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “Төсвийн захирагч батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт зөрчигдсөн байна. Аймгийн ЗДТГ захиалагчийн техник хяналтын зардлын мөнгийг хүлээн авсан хэдий ч зориулалтын дагуу хяналт хэрэгжүүлэхэд зарцуулаагүй, хяналт хэрэгжүүлсэн тайлан байхгүй байна.

Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэмд Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна” гэж заасан байна.

ГХБХБГ захиалагчийн хяналт тавьж, нэг ТАХ-нд 2-5 удаа хэрэгжүүлдэг хэдий ч хяналт хэрэгжүүлсэн тайлангаа бүрэн бичиж баримтжуулаагүй байна. Тухайлбал: Замын-Үүд суманд хэрэгжсэн замын 4 ажлын тайлан байхгүй, аймгийн ХО-аар хэрэгжүүлсэн 12 ТАХ-ний хяналтын тайлан, дүгнэлт байхгүй байна.

ГХБХБГ-ын Барилга, хот байгуулалтын хэлтэс нь хэлтсийн дарга 1, барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн 1, инженерийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн 1, барилгын материалын үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан 1, хот байгуулалтын кадастр, зураг төсөл, магадлалын асуудал хариуцсан 1, нийт 5 орон тоогоор ажиллаж байна. Улс, орон нутаг, ОНХС, бусад эх үүсвэрээр хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын ТАХ их байгаагаас шалтгаалж захиалагчийн хяналт хэрэгжүүлэх нэг мэргэжилтэнд 35-50 гаруй ТАХ ногддог байна. Ажлын ачаалал их байгаагаас зарим ТАХ-ний үе шат бүрд хяналт хэрэгжүүлж чадахгүйд хүрсэн, бичиг цаасны боловсруулалтын ажил орхигдох үр дагавар бий болжээ. Тус байгууллагын ажлын ачааллыг бууруулах, ТАХ бүрд хүрч ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, үе шатны хяналтыг хэрэгжүүлж хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн чанар, үр өгөөжийг сайжруулах шаардлагатай байна.

Захиалагч хяналт тавьж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах ажлыг зохион байгуулж ирсэн байна. Тухайлбал: Дэлгэрэх суманд Төрийн албан хаагчийн 4 айлын орон сууц барих ажлын гүйцэтгэгч Урбан девелопмент консалтинг групп ХХК-г гэрээний дагуу ажлаа гүйцэтгэхгүй, урьдчилж авсан хөрөнгийг /2019.08.05-нд 42.0 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгосон/ завшиж байгааг шалгуулахаар ГХБХБГ-аас 2019.10.17-нд аймгийн Цагдаагийн газарт албан бичиг хүргүүлснээр 2019.12.17-нд 42.0 сая төгрөгийг тус компани төлсөн байна.

Сайншанд сумын нийтийн орон сууцны дээвэр, дулаалга, гадна фасадны засварын багц-2 ажлын гүйцэтгэгч ТӨБЭМ ХХК техникийн тодорхойлолтод заасан хэмжээг өөрчилж ажлаа гүйцэтгэж байсан зөрчлийг илрүүлж 12 айлын орон сууцны гадна

дулаалгын хөөсөнцөр хавтан нь техникийн тодорхойлолтод 10 см-ын зузаантайгаар хийгдэх байтал 7 см-ын зузаан хөөсөнцөр хавтангаар гүйцэтгэж байсныг хяналтаар илрүүлж албан шаардлага хүргүүлсэн ч зөрчил арилаагүй, ТОБЭМ ХХК гүйцэтгэлийн төсвөөс дулаалгын хөөсөн хавтангийн үнийн зөрүүг хасаж тооцуулах албан бичиг ирүүлснээр ажлаа цааш үргэлжлүүлэн гүйцэтгэсэн байна.

Тус компанид 2020 онд олгох 58.6 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтээс ГХБХБГ-ын дүгнэлтийн дагуу гэрээний хугацаа хэтэрсэн алданги 1.4 сая төгрөг, дулаалгын хөөсөн полисрол хавтангийн үнийн зөрүү 1.3 сая төгрөг, ЗХЗ 1.0 сая төгрөг, зохиогчийн хяналтын зардал 0.5 сая төгрөг нийт 4.2 сая төгрөг суутгаж 2020.01.22-нд ТОБЭМ ХХК-д 54.4 сая төгрөг олгосон байна.

Ерөнхий боловсролын 1-р сургуулийн гадна хөл бөмбөгийн талбайг шинэчлэх ажлын гүйцэтгэгч Төгс-Өнөд ХХК ажлын тоо хэмжээгээр гүйлтийн талбайн гадуур хийгдэх хашааг дотор талаар нь гүйцэтгэсэн зөрчлийг илрүүлж бүх хашааг буулгуулан шинээр гүйлтийн талбайн гадна талаар хийлгэсэн байна.

Гүйцэтгэгчийн тендерийн материалд тусгаж ирүүлсэн инженер техникийн ажилтан, мэргэжлийн ажилчид, тоног төхөөрөмж, техник нь бодит байдалд үнэн зөв, бүрэн ажилласан эсэхэд тавих хяналт сул, үе шатны хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна. Зарим компаниуд ур чадвар муутай, туршлагагүй ажилчид ажиллуулах, техник хэрэгсэл дутагдах, зохион байгуулалтгүй байх зэргээс ажлын чанар, бүтээмж нь буурч, гэрээний хугацааг хэтрүүлсэн, сунгасан, өнөөг хүртэл ашиглалтад оруулаагүй байна.

2.3.2. Ажлын бодит гүйцэтгэлээр санхүүжилт олгоогүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 81 ТАХ-нд 9032.7 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 8690.8 сая төгрөгийн санхүүжилтийг 2019 онд олгожээ.

Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.16-д “Барилгын ажлыг батлагдсан зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй, чанаргүй, дутуу гүйцэтгэсэн, захиалагч болон эрх бүхий байгууллагын шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд захиалагч барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийг баталгаажуулахгүй. Энэ тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч болон хөрөнгө оруулагч санхүүжилт олгохгүй байж болно”, Сангийн сайдын 415 дугаар тушаалаар баталсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журмын 4.12-т “Төсвийн магадалшгүй ажлын зардлыг зөвхөн захиалагч, гүйцэтгэгч байгууллагын хамтран тогтоосон акт, магадалшгүй ажлын төсөв, гүйцэтгэлийг үндэслэн олгоно” гэсэн заалт зөрчигдсөн байна.

Аудитад хамрагдсан 6954.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 42 ТАХ-ний гүйцэтгэлийг тулгахад зарим ТАХ-нд ажлын гүйцэтгэл гаргуулж, хянан баталгаажуулахгүй санхүүжилт олгосон байна. Тухайлбал: Аудитын дүнгийн хэсгийн 2.2.1-д дурдсан 9 ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгоогүй байна.

Улаанбадрах сумын төвлөрсөн шугам сүлжээний цэвэр усны шугамын угсралтын ажил: 720.2 сая төгрөгийн гэрээний үнэтэй цэвэр усны шугамын угсралтын ажлын гүйцэтгэгч Гом илч ХХК зөвхөн газар шороог ухаж бэлтгэх, усан сангийн ажил хийсэн бөгөөд шугам хоолойг трасст байрлуулах, үзлэгийн худгууд хийгдээгүй зэргээр ажил дуусаагүй, гүйцэтгэл хянагдаагүй байхад 714.0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна. Мөн техник хяналтын зардлын 70 хувь буюу 8.7

сая төгрөгийг ГХБХБГ, 30 хувь буюу 3.7 сая төгрөгийг аймгийн ЗДТГ-т нийт 12.5 сая төгрөгийг захиалагчийн хяналтын зардалд тус тус олгосон байна. Цэвэр усны шугам сүлжээний ажлын гүйцэтгэлийг бодитой тооцож хянаагүй зөрчлийг арилгуулахаар ГХБХБГ-т албан шаардлага хүргүүлээ.

Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын санхүүжилтээс оны эцэст гүйцэтгэгч, захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж хийгдээгүй 3 ТАХ-ний 68.53 сая төгрөгийг барьцаа дансанд байршуулж, он дамжин хэрэгжих 16 ТАХ-ний 1996.8 сая төгрөгийн санхүүжилтийн үлдэгдэлтэй байна. Санхүүжилтийн үлдэгдлийг **хавсралт 3-т харуулав.**

Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтын дансанд 2019 онд санхүүжүүлэхээр анхны тогтоолын дүнгээр баталсан 1035.5 сая төгрөгийн, Чандмань бадрал ХХК-д тавьсан төлбөрийн актын 19.8 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэнээр нийт 1055.4 сая төгрөгийн орлого орсон байна. Тус данснаас 1041.4 сая төгрөгийн ТАХ-ний санхүүжилт, ГХБХБГ-т ЗХЗ 11.4 сая төгрөг, иргэн Ч.Хангарьдад ЗХЗ болох 0.7 сая төгрөг тус тус олгож, 1.9 сая төгрөгийг дээд шатны төсөвт төвлөрүүлжээ.

НББ-ийн тухай хуулийн 5.1.4-д заасан НББ-ийн үнэн зөв байх зарчмыг зөрчиж, өр, авлагын бүртгэл хөтөлж тайлагнаагүй байна. Тодруулбал: Цэвэр усны шугам сүлжээний ажлын гүйцэтгэл гарсан байхад 16.6 сая төгрөгийн санхүүжилт олгоогүй, 3 иргэнтэй байгуулсан 19.1 сая төгрөгийн ажлын үнээс суутгасан 1.9 сая төгрөгийн ХХОАТ-ыг шилжүүлээгүй, ТАХ-ний техник хяналтын зардал болох 5.8 сая төгрөгийг ЗАА-нд шилжүүлээгүй, хэмнэлтээр тооцож хөрөнгө оруулалтын ажилд төлөвлөж зарцуулсан байна.

Сангийн сайдын 415 дугаар тушаалаар баталсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журмын 5.4-т “Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна” гэж заасны дагуу ТАХ-ний гүйцэтгэлийг үнэн зөв гаргаж байгаа эсэх, ТАХ-ний санхүүжилт, барилгын чанарт тавих хяналтаа сайжруулах хэрэгтэй байна.

2.3.3. Хөрөнгө оруулалтын явцад тавих дотоод аудитын хяналт үгүйлэгдэж байна.

Санхүүгийн хяналт аудитын албаны 2020 оны 01-р сарын 27-ны 13 тоот албан бичгээр 2019 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудад хяналт шалгалт хийгдээгүй гэсэн тайлбарыг ирүүлсэн. Тус байгууллага өмнөх онуудын хөрөнгө оруулалтад хуулийн дагуу² хяналт шалгалтыг зохион байгуулж байгаагүй байна.

Эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дээрх алба нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн ТАХ-нд хяналт хийх, үнэлэлт, дүгнэлт зөвлөмж гаргаж ажиллаагүйгээс хөрөнгө оруулалтад тавих дотоод аудитын хяналт орхигдож байна.

²Төсвийн тухай хуулийн 69 зүйл Дотоод аудит 69.1.Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна,

Бүлэг 3

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ашиглалтыг сайжруулах, аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

3.1. Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн алдаанаас шалтгаалж хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээг бүрэн ашиглаагүй байна.

3.1.1. Хэрэгжүүлсэн ТАХ зориулалтын дагуу бүрэн ашиглагдаж байна уу.

3.1.1. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн зарим ТАХ ашиглагдаагүй, хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 589.8 сая төгрөгийн гэрээний үнэтэй 2 ТАХ инженерийн дэд бүтцийн асуудал шийдэгдээгүйгээс ашиглалтгүй байна.Тухайлбал:

- **Замын-Үүд сумын халуун ус барих ажил:** Барилгын гадна инженерийн шугам сүлжээг зураг төсөлд заасан худагт холболт хийсэн боловч уг худагт дулааны эх үүсвэрийн шугам байхгүйгээс шалтгаалж ашиглалтгүй байгаа бөгөөд дэд бүтцийн асуудал шийдтэл зориулалтаар ашиглах боломжгүй байна.
- **Замын-Үүд суманд Иргэдийн хөгжлийн төвийн барилга барих ажил:** Барилга угсралтын үндсэн ажил хийгдсэн боловч гадна дулааны эх үүсвэр байхгүй, инженерийн шугам сүлжээ холбогдох боломжгүйгээс дэд бүтцийн асуудал шийдтэл ашиглагдах боломжгүй байна.

Аймгийн төвийн 1-р зэрэглэлийн зарим хэрэглэгчдийг /Нэгдсэн эмнэлэгт/ цахилгааны нөөц эх үүсвэртэй болгох ТАХ-г "Лайшил" ХХК 34.9 сая төгрөгөөр гүйцэтгэж 2019.07.30-нд 2 ширхэг цахилгаан үүсгүүрийг комисс хүлээн авсан байна. Анх төсөв батлахдаа Нэгдсэн эмнэлгийн хэрэгцээнд зориулж авсан гэх боловч БНЗӨБЦТС-ын хашаанд 2 үүсгүүрийг байрлуулсан байна. Тус үүсгүүрийн 1-ийг аймгийн ЗДТГ-т бүртгэсэн, нөгөөг БНЗӨБЦТС данс бүртгэлдээ тусгах саналаа ТӨХ-нд хүргүүлээд хариу хүлээж байна. Энэхүү 2 цахилгаан үүсгүүрийг хүлээн авсан цагаас хойш ашигласан тухай бүртгэл байхгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн дээрх ТАХ ашиглалтгүй байгаа нь хөрөнгө оруулалтын үр ашиг, үр нөлөөг бууруулж байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”-ыг НББ-д заавал бүртгэнэ, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журмын 6.1-д “Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх бөгөөд барилга байгууламжийг барьж дуусгах хүртэл, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр захиалагч байгууллага эргэлтийн бус хөрөнгөөр бүртгэн санхүүгийн тайландаа тусгана, Их засварын зардлыг захиалагч байгууллага нь хөрөнгийн дүн, засварын төрлөөр тодруулга тайланд тусгана” гэж заасан. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-ний 166.9 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна. Үүнд:

- Сайншанд сумын 1-р сургуулийн хөл бөмбөгийн талбай 109.0 сая төгрөг
- Эрдэнэ сумын 6 бункертэй хогны машин 50.0 сая төгрөг
- Даланжаргалан сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах 7.9 сая төгрөг

Иймд бүртгээгүй хөрөнгийг данс бүртгэлд тусгуулах 166.9 сая төгрөгийн нэг албан шаардлага бичлээ.

3.1.2. Хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр өгөөж, үр нөлөөг тооцож дүгнээгүй, мэдээллийн бааз суурийг бүрдүүлээгүй байна.

Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтаар хийгдсэн ихэнх ажлууд нь иргэдийн талархлыг хүлээсэн, цаг үеэ олсон, олон нийтийн эрх ашигт нийцсэн ажлууд болжээ. Тухайлбал:

- Сайншанд, Замын-Үүд сумдад нийт 1805.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 Багийн иргэдийн хөгжлийн төвийг барьж ашиглалтад оруулсан бөгөөд тус барилгад багийн ажлын алба, Өрхийн эрүүл мэндийн төв, Цагдаагийн хэсэг зэрэг байгууллагууд төвлөрч үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлснээр иргэд төрийн үйлчилгээг нэг дороос түргэн шуурхай хүртэж байна.
- Аймгийн төвд нийт 600.0 сая төгрөгөөр 12 орон сууцны гадна фасад, дээврийг засварласан нь нийтийн орон сууцны дулаан алдагдлыг бууруулж, иргэдийн тав тухтай орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхээс гадна хотын өнгө үзэмжид сайнаар нөлөөлсөн ажил болсон.

Аймгийн хөрөнгө оруулалтын хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж, иргэдийн ажиллах, амьдрах ая тухтай байдал дээшилсэн, үйлдвэр, үйлчилгээний цар хүрээ өргөжин тэлж байгаа хэдий ч хөрөнгө оруулалтын хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний үр ашиг, үр өгөөжийг үндэслэлтэй гүйцэтгэх арга барил дутагдаж байна.

Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн ТАХ хэрэгжсэнээр ажлын байр, иргэдэд үйлчлэх үйлчилгээний цар хүрээ хэрхэн нэмэгдэх нөхцөл боломж бүрдэх, мөн ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан хөрөнгө оруулалтын үр ашиг, үр дүнг тооцсон дүгнэлт байхгүй, байна.

Хөрөнгө оруулалтын бүх эх үүсвэрээр хэрэгжих ТАХ-ний төлөвлөлт, гүйцэтгэл, хэлтсийн бусад үйл ажиллагааны чиг үүрэг, ажлын даалгаврыг нэг мэргэжилтэн гүйцэтгэж байгаагаас хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хяналт, судалгаа шинжилгээний ажил орхигдож байна. Аймаг, сумын хөрөнгө оруулалтын ажлыг төлөвлөх, статистик үзүүлэлт, суурь түвшин, хэрэгцээ шаардлага, мэдээллийн баазыг бий болгох хэрэгтэй байгаа тул хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хариуцаж хэрэгжүүлэх ажлын байр зайлшгүй шаардагдаж байна.

3.2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчил давтагдан гарсаар байна.

3.2.1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн А/92 дугаар тушаалаар баталсан Гүйцэтгэлийн аудитын журмын 13.1-д “Төрийн аудитын байгууллагын нэг гол зорилт бол аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг хангуулах замаар улсын хэвшлийн ажлын гүйцэтгэл, хариуцлагыг сайжруулах явдал юм” гэж тусгасан.

“Орон нутгийн төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар аймгийн Засаг даргад 1, АЗДТГ-т 1, ОНӨГ-т 1, ГХБХБГ-т 1 нийт 4 зөвлөмж хүргүүлж, АЗДТГ-т 1, ГХБХБГ-т 1, нийт 2 албан шаардлага өгсөн байна.

Орон нутгийн өмчийн газарт өгсөн “Үнэлгээний хороодод тендерийн бичиг баримт боловсруулах, тендер зохион байгуулах талаар мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч ажиллах” гэсэн нэг зөвлөмж хэрэгжсэн байна.

Тодруулбал: Худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлсэн болон бусад эх үүсвэрээр санхүүжигдэх ТАХ-ний сум орон нутгийн байгууллагуудын ХАА-нд зөвлөмж чиглэлийг албан бичгээр өгч ажилласан бөгөөд цахим системийн зөвлөмжийг өдөр тутам өгч ажилласан байна. Төсөвт байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээд, 14 сумдын худалдан авах ажиллагаа хариуцсан албан хаагчдад “Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, цаашид анхаарах асуудал” сэдэвт сургалтыг зохион байгуулсан байна.

Бусад байгууллагуудаас зөвлөмжийг хэрэгжүүлэхээр зохион байгуулсан ажлын мэдээ, тайлан болон албан шаардлагын хэрэгжилтийг ирүүлсэн хэдий ч хэрэгжилт нь хангалтгүй байна. Тухайлбал:

-Аймгийн Засаг даргад: Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 3.1, 3.2 дахь заалтуудыг хэрэгжүүлэх,

-Аймгийн ЗДТГ-ын даргад: Засгийн газрын 2017 оны 170 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн дагуу захиалагчийн хяналт хэрэгжүүлэх

-Хөрөнгө оруулалтын ажлыг техникийн тодорхойлолт, гэрээний дагуу бүрэн гүйцэтгэсэн эсэхийг хянах гэсэн зөвлөмжийн дагуу хяналт тавьж ажилласан ч зарим ТАХ-ний хяналт хангалтгүй байна.

3.2.2. Өмнөх аудитаар илэрсэн зөрчил давтагдан гарсан уу

3.2.2. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаагүй, давтан гаргасаар байна.

Өмнөх аудитаар илэрсэн зөрчил дахин давтагдан гарсан байна. Үүнд:

- Тухайн шатны төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулалтын бус зардлыг төлөвлөж батлуулсан.
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зураг төсөвгүй ТАХ-г төлөвлөж батлуулсан
- Гүйцэтгэгч хөрөнгө оруулалтын ажлыг ТББ болон гэрээний дагуу бүрэн гүйцэтгээгүй.

Өмнөх аудитаар илэрсэн зөрчил давтагдан гарч байгаа нь аймгийн ИТХ, Засаг дарга, харьяа байгууллага, холбогдох ажилтнуудын ажлын хариуцлага хангалтгүй байгааг харуулж байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг нарийвчилж судлаагүй, тэргүүлэх ач холбогдол, зориулалт, шинж чанараар ангилаагүй, үр ашгийн тооцоо судалгаа хийгээгүй ТАХ төлөвлөсөн нь нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдаагүй байна.

Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, урсгал зардал, санхүүжүүлэх эх үүсвэрийг тооцоогүй 2663.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ, барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлт зэргийг үндэслээгүй 1037.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 их засварын ажлыг төлөвлөсөн байна.

Нэр байршил тодорхойгүй 643.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ, 1532.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ зураг төсөвгүй, 290.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ-г газрын зөвшөөрөлгүй байхад төлөвлөж, түүнийг нь аймгийн ИТХ баталсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д заасныг зөрчиж байна.

Сайншанд сумын 4, 7 дугаар багийн малчдын бэлчээрийг усжуулах инженерийн хийцтэй худаг гаргах 24.3 сая төгрөгийн ажил нь усны хайгуул хийгдээгүйн ус гараагүй байна.

Төсвийн тухай хуулийн заалтыг зөрчиж тухайн шатны төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй хөрөнгө оруулалтад аймаг 240.0 сая төгрөг, хөрөнгө оруулалтын бус зардалд 75.0 сая төгрөг, Замын-Үүд сум хөрөнгө оруулалтын зардлын 50 гаруй хувь буюу 541.0 сая төгрөгийн ТАХ төлөвлөж, ИТХ-аар батлуулжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр болон ОНХС, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх зэрэг эх үүсвэрээр 2019 онд хэрэгжүүлэх ТАХ-ний тоо олон, барилгын компаниудын гэрээт ажлын хугацаа давхцах, тендерт оролцогч ирэхгүй байх, тендер дахин зарлах зэргээс ХАА төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй байна.

Тендерийн баримт бичигт ХАА-ны хуульд заасан санхүүгийн болон техникийн шаардлагыг бүрэн тусгаагүй, хүчин чадал, эдийн засгийн үр ашигт байдал, хэрэглээ, ашиглалтын үзүүлэлтийг сайн судалж техникийн тодорхойлолтыг боловсруулаагүй байна.

Захиалагч гүйцэтгэлийн баталгаа шаардаагүйгээс 326.3 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгаа байршуулаагүй, гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй гүйцэтгэгчийн байршуулсан 87.3 сая төгрөгийн тендерийн баталгааг улсын орлого болгоогүй байна.

Замын-Үүд сумын ЗАА гэрээний үнийн дүнгээр гэрээ байгуулсан өдөр 253.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

ХАА-г зохион байгуулахдаа 1639.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ-нд хууль болон ТББ-т тусгасан зарим шаардлагыг хангаагүй оролцогчийг сонгон шалгаруулсан

нь ХАА ил тод биш, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөлийг бүрдүүлсэн, хуулийн дагуу зохион байгуулагдаагүй байна.

Тендерт ирүүлсэн баримт бичигт тусгагдсаны дагуу ажиллах хүч, машин техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлаа бүрэн ашиглаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, гэрээний хугацааг хэтрүүлсэн, сунгасан, ажлаа дуусгаж актаар хүлээлгэн өгөөгүй 13 ТАХ, 1211.9 сая төгрөгийн санхүүжилтийг урьдчилгаа хэлбэрээр болон 100 хувь бүрэн авсан 9 ТАХ байна.

Замын-Үүд сум нэг ТАХ-ний гүйцэтгэсэн ажлын санхүүжилт 16.6 сая төгрөгийг олгоогүй, гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлын үнээс суутгасан 1.9 сая төгрөгийн ХХОАТ-ыг шилжүүлээгүй, ЗАА-нд техник хяналтын зардал болох 5.8 сая төгрөгийг шилжүүлээгүй, хэмнэлтээр тооцож хөрөнгө оруулалтын ажилд төлөвлөж зарцуулсан байна.

Аймгийн ЗДТГ захиалагчийн техник хяналтын зардлын 36.1 сая төгрөгийг зориулалтын дагуу хяналт хэрэгжүүлэхэд зарцуулаагүй, хяналт хэрэгжүүлсэн тайлан байхгүй байна.

Улс, орон нутаг, ОНХС, бусад эх үүсвэрээр хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын ТАХ их байгаагаас шалтгаалж ажлын ачаалал ихэссэн, ТАХ-ний үе шат бүрд хяналт хэрэгжүүлж чадахгүйд хүрсэн, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шатанд хийгдэх хяналт, судалгаа, шинжилгээний ажлууд орхигдсон байна.

ОНТХ-өөр хэрэгжүүлсэн 589.8 сая төгрөгийн гэрээний үнэтэй 2 ТАХ инженерийн дэд бүтэц шийдэгдээгүйгээс ашиглалтгүй байна.

Хөрөнгө ашиглагч байгууллагын зүгээс хүлээн авсан хөрөнгөө бүртгэлдээ тусгахаар ОНӨГ болон ХОХБХ-т хандаж албан бичиг хүргүүлдэг боловч хөрөнгийн үнэ болон бусад холбогдох баримт бичгийг хугацаанд нь гаргаж өгөөгүйгээс комиссын актаар хүлээн авсан 166.9 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлд тусгагдаагүй байна.

Аймгийн ИТХ, Засаг дарга, харьяа байгууллага, холбогдох ажилтнуудын ажлын хариуцлага хангалтгүй байгаагаас хөрөнгө оруулалтаар бий болох бараа, ажил үйлчилгээ, барилга, засварын ажил, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь ашиглагч, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг зорилтот хугацаанд хангаж чадахгүй байдалд хүрч, хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулж байна.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхээр зохион байгуулсан ажлын мэдээ, тайлан болон албан шаардлагын хэрэгжилтийг ирүүлсэн хэдий ч зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, зөрчил давтагдан гарсаар байна.

Аудитаар нийт 11384.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж гэрээ дүгнэж алданги тооцуулах, ажлын бодит гүйцэтгэлийг хянаж баталгаажуулах, хөрөнгө данс бүртгэлд бүртгэх тухай 166.9 сая төгрөгийн 3 албан шаардлага бичиж 11431.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон, Утас/Факс: (976) 7052 3036,
И-мэйл: zdtg@dornogovi.gov.mn, Вэбсайт: dornogovi.gov.mn

2020. 05. 05 № 3/464
танай 2020. 04. 29 -ны № 16/401 -т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тайлангийн төсөлд санал хүргүүлэх тухай

Танай байгууллагын 2020 оны төлөвлөгөөний дагуу хийгдсэн “Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлд дараах саналыг оруулж байна. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтын ажлуудыг төлөвлөхдөө зөвхөн тухайн жилийн аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг үндэслэдэггүй, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр /2016-2020 он/-т тулгуурлан төлөвлөдөг. Иймд аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх тухайн оны үндсэн чиглэлд тусгагдаагүй зарим төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн болно.

2. Хуучин орон сууцны дээвэр, фасадны засварын ажил болон зарим сургууль, цэцэрлэг, эмнэлгийн хашаанд саравч, сүүдрэвч, сандал, гадна тохижилтыг сайжруулах ажил нь аймгийн ИТХ-аар батлагдахдаа нэр байршил нь тодорхой байсан. Гэвч энэ нь төсөл арга хэмжээний тоог олон болгож харагдуулж байснаас нэгтгэж, 1 ажлын нэрээр батлуулсан болно.


3. Зарим ажлууд нь аймгийн ИТХ-аар батлагдахдаа олон жилийн өмнө хийгдсэн зураг, төсвөөр батлуулсан учир, тухайн ажлын худалдан авах ажиллагааг зарлахад зураг, төсвийг зайлшгүй өөрчлөх шаардлагатай болдог. Үүнээс үүдэн зураг, төсвийг дараа нь батлуулж байна гэдэг асуудал гарч байна.

4. Аймгийн төвийн 1-р зэрэглэлийн зарим хэрэглэгчдийг цахилгааны нөөц эх үүсвэртэй болгох ажлын хүрээнд 34.9 сая төгрөгөөр 2 үүсгүүр худалдаж авсан.

Цахилгаан тасарсан үед эмнэлэг, Онцгой байдлын газар зэрэг шаардлагатай онцгой объектод ашиглана.

ДАРГА

Б.ГАНЗОРИГ





ДОРНОГОВЬ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,
Утас: 7052 3998, И-мэйл: domogovi@gazar.gov.mn

2020.05.05 № 344
танай _____-ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ч.АРИУНАА

Ч. Ариунаа
2020.05.05

Санал хүргүүлэх тухай

Танай байгууллагаас ирүүлсэн "Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдвийн хүрээнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцан дараах тайлбар, тодруулгыг хүргүүлж байна. Үүнд:

1. Хөвсгөл сумын Багш нарын 4 айлын орон сууц барих ажлыг ашиглалтад хүлээн авсан хуралдааны тэмдэглэл нь төрийн архивт хүлээлгэн өгсөн баримт бичигт байгаа бөгөөд манай газарт үлдсэн баримтад үдэгдээгүй орхигдсон байсныг хавсралтаар хүргүүлэв.

2. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын их засварын ажил, Сайншанд сумын 3 дугаар багийн цэвэр усны шугам сүлжээний ажил, Төмөр замын Орос давхрын дээврийн засварын ажлуудыг ашиглалтад хүлээн авах комисс ажиллах үед чанаргүй буюу дутуу хийгдсэн ажлууд байхгүй байсан ба комиссын гишүүдээс барилгын холбогдох баримт бичгийг бүрдлийг хангах, чанарын баталгаа гаргаж баримтад хавсаргах зэрэг үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулсан болно. Мөн гишүүдийн зүгээс ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй боловч зайлшгүй шаардлагаар нэмэлтээр өгсөн үүрэг даалгаврыг манай газрын хяналтын инженерүүд газар дээр нь биечлэн очиж шалгасан болно.

ДАРГА



Ц.ОЮУНСАЙХАН

**ДОРНОГОВЬ АЙМАГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Амгийн ЗДТГ-ын байр 104 тоот,
Утас/факс: (705) 2-00-04

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

2020.05.06 № 186
танай _____ -ны № _____ -т

**Тайлангийн төсөлд санал
хүргүүлэх тухай**

Танай байгууллагын 2020 оны төлөвлөгөөний дагуу хийгдсэн "Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлд дараах саналыг оруулж байна. Үүнд:

1. Манай газраас тендер шалгаруулалтыг зохион байгуулахдаа тендерийн баримт бичигт гүйцэтгэлийн баталгааг гэрээний үнийн дүнгийн 5 хувиар ирүүлэхээр зааж өгсөн болно.

2. Улаанбадрах сумын төвлөрсөн шугам сүлжээний цэвэр усны шугамын угсралтын 789,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын тендерт үнийн санал ирүүлсэн 2 оролцогчтой.

"Гом Илч" ХХК-ийн хувьд: тендерийн баримт бичгийн шалгуур үзүүлэлт ТШӨХ-ийн ТӨӨЗ-д түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Тендерт оролцогч нь төсөвт өртгийн 80 хувьтай тэнцэх мөнгөн ба түүнтэй адилтгах хөрөнгийн эх үүсвэртэй байх ба түүнийг баталгаажуулсан баримт /дансны үлдэгдлийн банкны тодорхойлолт, авах боломжтой зээлийн тодорхойлолт "авах боломжтой зээл гэдэгт зээлжих баталгаажсан эрх, харилцагч банкнаас зээл олгох албан мэдэгдэл зэрэг байж болно" гэх мэт/-ийг гаргаж ирүүлэхээр зааж өгсөн шаардлага болон тендерийн баримт бичгийн бусад шаардлагыг хангаж тендерт "Хамгийн сайн" үнэлэгдсэн тендерээр шалгарсан.

"Б СОФТ" ХХК-ийн хувьд: ТШӨХ-ийн шалгуур үзүүлэлт ТӨӨЗ 5.2 (б)-д 2017 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг ирүүлээгүй, мэдэгдэл гаргахдаа захиалагчийн нэрийг өөр аймагт гаргасан, төсвийн тооцоог хийхдээ магадлашгүй ажлын зардлыг БУА-ын төсөвт өртгийн 3 хувиар тооцож ирүүлсэн нь БНБД 81-94-12-н 6.46 заалтыг зөрчиж ирүүлсэн тендерийн шаардлага хангаагүй учраас тендерт шалгараагүй болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3-д шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлэх үндсэн шалгуур нь тендерийн үнэ байна гэж заасан болно.

ДАРГА

У.БАЯРБИЛЭГ



172180018



**ДОРНОГОВЬ АЙМАГ
ЗАМЫН-ҮҮД СУМЫН ЗАСАГ ДАРГА**

44013 Дорноговь аймаг, Замын-Үүд сум, Борхойн тал,
Утас: (705) 2-75-55, факс: (705) 2-75-55
И-мэйл: www.zamiin-uud.do.gov.mn

2020.05.06 № 1/448

танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Ч.АРИУНАА ТАНАА

Тайлбар хүргүүлэх тухай

Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийсэн тайлантай танилцлаа.

Хөрөнгө оруулалтын ажлын хэрэгцээ шаардлага төлөвлөлтийг сайжруулан, худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэн, төсөл арга хэмжээг гэрээний хугацаанд гүйцэтгэхэд нь тавих хяналтыг сайжруулах талаар анхааран ажиллаж, хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулан цаашид аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахад анхаарах болно.



Н.АЛДАРБАЯР

2020.05.20 01:01

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Аймгийн ЗДТГ-т өгөх тайлбар:

1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16.4-т “Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд үндэслэн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулна” гэж заасан байх тул аудитын дүнд өөрчлөлт оруулаагүй болно.

ГХБХБГ-т өгөх тайлбар:

1. Саналд дурдагдсан ТАХ-ний тайлбар тодруулгын дагуу аудитын дүн, дүгнэлтийн хэсгээс хассан болно.

ОНӨГ-т өгөх тайлбар:

1. Хуулийн дагуу гүйцэтгэлийн баталгаа шаардах, ирүүлээгүй тохиолдолд тендерийн баталгааг улсын орлого болгох зөвлөмжийг аймгийн ЗДТГ-т хүргүүллээ.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна.

Аймгийн ИТХ-ын дарга С.Түмэнбаяр, Замын-Үүд сумын ИТХ-ын дарга Б.Анхбаяр танаа:

1. Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх ТАХ нь техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон, инженер хайгуулын судалгаа хийгдсэн, мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан байхын зэрэгцээ нийгмийн ач холбогдолтой, үр өгөөжтэй, зардал мөнгө хэмнэсэн байх шаардлагад нийцүүлж төсөв батлах
2. ТАХ-г нийгэм эдийн засгийг хөгжүүлэх тухайн оны үндсэн чиглэлтэй уялдуулах, тухайн шатны төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах ТАХ-нд төсөв батлах

Дээрх зөвлөмжийн хариуг 2020 оны 12 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин, Замын-үүд сумын Засаг дарга Н.Алдарбаяр танаа:

1. Хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, тэргүүлэх ач холбогдол, зориулалт, шинж чанараар ангилж, үр ашгийн тооцоо судалгаа хийсэн, хууль, эрх зүйд нийцүүлж боловсруулсан, санхүүжүүлэх эх үүсвэрийг зөв хуваарилсан, тухайн онд хэрэгжүүлж, санхүүжилтийг бүрэн олгох ТАХ-ний саналаа ИТХ-д оруулах
2. ТАХ-г бодитой төлөвлөх нөхцөлийг бүрдүүлж хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хяналт, шинжилгээ хариуцсан мэргэжилтний ажлын байр шинээр бий болгох
3. ТАХ-г гэрээний хугацаанд гүйцэтгэхэд тавих хяналтыг сайжруулах дотоод аудитын хяналтыг хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн хариуг 2020 оны 12 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аймгийн ЗДТГ-ын дарга Б.Ганзориг, Замын-Үүд сумын ЗАА-ны дарга Ц.Саруулсайхан танаа:

1. Барилгын ажлын гүйцэтгэлийг зохиогчийн болон захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлттэй уялдуулан хянах, ашиглалтад оруулахад нөлөөлөх хүчин зүйл байгаа эсэхийг хэлэлцэж дүгнэх
2. Захиалагчийн хяналтыг ТАХ бүрд хүрч ажиллах нөхцөлийг бүрдүүлж хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн чанар, үр өгөөжийг сайжруулах
3. Гүйцэтгэгч тендерт ирүүлсэн ажиллах хүч, машин техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлаа бүрэн ашиглаж байгаа эсэхэд явцын хяналт тавих
4. Гэрээ байгуулах эрх олгогдсон компани тендерийн баримт бичиг дэх гэрээний тусгай нөхцөлд шаардсан гүйцэтгэлийн баталгааг байршуулаагүй тохиолдолд тендерийн баталгааг улсын орлого болгох
5. Барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажил болон тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилт зэрэг бусад

баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх төлөвлөгөө, гэрээнд заасны дагуу сар бүр хянан баталгаажуулж, чанаргүй, дутуу гүйцэтгэсэн, шаардлага биелүүлээгүй тохиолдолд барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийг баталгаажуулахгүй байх

6. Хөрөнгө оруулалтын үр өгөөж, үр нөлөөг тооцож ажиллах
7. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах
8. Хэмнэгдсэн төсөв, өр төлбөрийн дүнг нягтлах, НББ-ийн дагуу хөрөнгийг данс бүртгэлд тусгуулах
9. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-г комиссын актаар хүлээн авсан даруйд холбогдох баримт бичгийг ашиглагч байгууллагад хугацаанд нь хүргүүлж хөрөнгийг данс бүртгэлд тусгуулах

Дээрх зөвлөмжийн хариуг 2020 оны 9 дүгээр сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Орон нутгийн өмчийн газар дарга У.Баярбилэг, Замын-Үүд сумын ЗАА-ны дарга Ц.Саруулсайхан танаа:

1. Тендерийн баримт бичигт санхүүгийн болон техникийн шаардлагыг хуулийн дагуу тусгах, мэргэжлийн ажилчид, зөвлөхийн орон тоо, цалингийн зардлын тооцооны хүснэгт ирүүлэх болон тухайн гүйцэтгэгч компанийн зүгээс тавих чанарын хяналтын арга хэмжээг шаардах
2. ТАХ-ний хүчин чадлын үзүүлэлт, эдийн засгийн үр ашигт байдал, хэрэглээ, ашиглалтын үзүүлэлтийг сайн судалж техникийн тодорхойлолтыг боловсруулах
3. Гэрээний тусгай нөхцөлд хуулийн дагуу гүйцэтгэлийн баталгааг тусгах /ЗАА/
4. ХАА-ны хуулийн заалтыг хэрэгжүүлж ТББ-т урьдчилгаа төлбөр төлөх эсэхийг тусгаж байх
5. Оролцогчийн тендерийн үнэлгээг хийхдээ ТББ-т тусгасан шалгууруудыг хангасан эсэхийг нягталж хуулийн дагуу хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллах
6. Үнэлгээний хорооны гишүүдийг ХАА-ны сургалтад хамруулж, мэргэшүүлэх
7. Барилгын ажил эрхлэх хугацаанаас хойш тендер зарлахгүй байх

Дээрх зөвлөмжийн хариуг 2020 оны 9 дүгээр сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

ГХБХБГ-ын дарга Ц.Оюунсайхан танаа:

1. ТАХ-ний үе шатны ажилд тавих хяналтаа сайжруулж Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх
2. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэх орон тоог оновчтой байдлаар шийдвэрлэж ТАХ-ний үе шат бүрд хүрч хяналт тавих

Дээрх зөвлөмжийн хариуг 2020 оны 12 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч. АРИУНАА

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД :

Аудитор

П.Энхбаяр

Ахлах аудитор

Ц.Лүндэгмаа

ХЯНАСАН:

Аудитын менежер

Ч.Хэрлэнчимэг



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АУДИТОРЫН
ТУШААЛ

2020 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/13

Дорноговь аймаг, Сайншанд сум

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн Аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйлийн 15.2, 19 дүгээр зүйлийн 19.3.3, Монгол улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/95 тоот тушаал, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дугаар зүйлийн 40 дэх заалт, 2018 оны А/207 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан, 01/89 ДГА-2020/01/-ГА, 02/90 ДГА-2020/01/-ГА, 03/91 ДГА-2020/01/-ГА дугаар бүхий албан шаардлагыг тус тус баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн ЗДТГ, ОНӨГ, ГХБХБГ, Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны дарга нарт, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга, Замын-Үүд сумын засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.
3. Аудитын тайланг аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга, ГХБХБГ, аймгийн ЗДТГ, ОНӨГ, Замын-Үүд сумын Засаг дарга, Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албаны дарга нарт хүргүүлсүгэй.
4. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Ч.Хэрлэнчимэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Ч.АРИУНАА

